

“ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ” ЗОРИЛТОТ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

ТӨГРӨГ СУМ

2023-12-18

1.Удирдлага зохион байгуулалтын талаар: Хэрэгжүүлэх ажил үйлчилгээ:

1-1. “Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх” зорилтот жилийн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллах

1-1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 15/05 дугаар тогтоолоор 2023 оныг “Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх” жил болгон зарласан. Энэ тогтоолын дагуу Засаг даргын А/14 дугаар захирамжаар Засаг даргын орлогчоор ахлуулсан 15 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан төлөвлөгөө гарган Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн дугаар 10/02 тогтоолоор 5 зорилтын хүрээнд 32 ажил үйлчилгээг батлуулан ажилласан.

❖ Зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг гаргахад бүрэн хэрэгжсэн 13 заалт, 95 хувьтай хэрэгжсэн 6 заалт, 90 хувьтай хэрэгжсэн 8 заалт, 80 хувьтай хэрэгжсэн 1 заалт, 70 хувьтай хэрэгжсэн 3 заалт, 30 хувьтай хэрэгжсэн 1 заалт төлөвлөгөөний биелэлт **92,8** хувьтай дүгнэгдлээ.



1-2. “Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх жил”-ийн нээлтийн арга хэмжээ зохион байгуулах, оролцох

1-2. Зорилтот жилийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, тус арга хэмжээнд Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, албаны дарга, мэргэжилтэн, “BEST” хөтөлбөрийн төслийн зөвлөх зэрэг 11 хүн оролцож, мэдээлэл сургалт зохион байгуулж, Хоол үйлдвэрлэгч төсөвт байгууллагууд болох ЕБС болон Цэцэрлэг, ЭМТөв хоолны үзэсгэлэн үндэсний үйлдвэрлэгч Чиглэл ХХК-ы Хүнсний зориулалтын зэвэрдэггүй ган савнуудын танилцуулга, худалдаа зэрэг боллоо.

ЗОРИЛТОТ ЖИЛИЙН НЭЭЛТЭЭС



1-3. “Тариаланчдын зөвлөгөөн” зохион байгуулах

1-3. Тариаланчдын зөвлөгөөнийг зорилтот жилийн нээлтийн арга хэмжээтэй хамт зохион байгуулж, 3 төрлийн гарын авлага тариаланчдад тараан өгч, зорилтот жилийн хүрээнд Газар тариалангийн салбарт хэрэгжүүлж хийж гүйцэтгэхээр төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг танилцуулж тариаланчдын саналыг сонслоо.



1-3. “МАЛЧДЫН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ” ОРОЛЦОХ

Аймгийн Засаг даргын 2023 оны А/373 дугаар захирамжын дагуу Монгол улсад мал үржлийн алба байгуулагдсаны 100 жилийн ойтой холбогдуулан “Малчдын бүсийн зөвлөгөөн”-ийг Баянгол суманд зохион байгуулж, Арвайхээр, Сант, Төгрөг, Баянгол сумын 370 гаруй малчид оролцож, ХХААГ болон аймгийн удирдлагууд, Арьс-Ирээдүй ХХК, Ноос-Ирээдүй ХХК-уудын танилцуулга мэдээлэлтэй танилцсан. Манай сумаас бүсийн зөвлөгөөнд 72 малчин оролцож, холбогдох дарга нараас асуулт асууж хариулт авч, 5 малчин Засгийн газрын болон аймгийн жуух бичгээр шагнууллаа



1-4. “Хөдөлмөр зуслан”-д сурагчдыг хамруулж, төмс, хүнсний ногооны тариалалт болон хураалтын талаар технологийн анхан шатны мэдлэгтэй болгох

1-4. Хөдөлмөр зусланг 10 гаруй жил Мазар баг дээр ажиллуулж байна. Энэ жил 3 хоногийн хугацаанд зохион байгуулж, хүнсний болон хүлэмжний ногоо, тариалалт, арчилгаа усалгаа мөн ахлах ангийн сурагчдаар чацаргана хураалт хийлгэсэн. Аймгийн аварга тариаланч Янжиндулам сурагчдад төмс, хүнсний ногооны технологийн дагуу тариалах, хөрсөө хэрхэн бэлдэх, шавьж мэрэгчин амьтадаас хамгаалах, усалгаа арчилгааг ямар хугацаанд хэрхэн хийвэл ургац арвин авах талаар зааж сургалаа. Төмс, хүнсний ногооны зэрлэг түүж төмсний цэцгийг таслахгүй, таних мөр гэмтээхгүй, бусдын хүнсний ногоог гэмтээхгүй түүх зэрэг чадварыг эзэмшлээ.



1-5. Зорилтот жилийн хүрээнд болзолт уралдаан зарлаж, дүгнэх

1-5. Үндэсний уламжлалт модон торх, ган нержен сав зэрэг хүнсний зориулалтын савтай өрх шалгаруулах болзолт уралдааныг сумын үзэсгэлэн худалдаагаар шалгаруулхад 3-р багийн Ц.Гончигдорж, 2-р баг С.Батжаргал албан байгууллагаас Хүүхдийн цэцэрлэг шалгарсан. Шилдэг төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгч, шилдэг хүлэмжийн аж ахуй эрхлэгч зэрэг болзолт уралдаанд 1 хоршоо, 1 иргэн, хүнсний зориулалтын сав суулга хэрэглэгч албан байгууллагад СӨББ-ын материалыг хүргүүлээд байна.



1-6. ОРОН НУТАГТ ҮЙЛДВЭРЛЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ АЙМАГ, БҮС, ОРОН НУТГИЙН ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНД НЭГДСЭН ЗОХИОН БАЙГУУЛАЛТАЙ ОРОЛЦУУЛАХ

1-6. **“Төгрөгт үйлдвэрлэв”** үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, 38 үйлдвэрлэгч, 32 малчид, албан байгууллагууд оролцож 3,4 сая төгрөгийг шагналд зарцуулан иргэдийнхээ үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон нийтэд суртачилж таниулах зорилгоор бичлэг хийж олон нийтийн сүлжээнд байршуулсан.



Дараах төрлүүдээр шилдэг номинацийг шалгаруулсан

Шилдэг үйлдвэрлэгч: “Хаяа баян говь” хоршоо

Шинэ сав баглаа боодол нэвтрүүлэгч иргэнээр: 2-р баг Ц.Өнөржаргал

Газар тариалангийн шилдэг үйлдвэрлэгчээр: ”Мазар далан булаг” хоршоо

Сүүн бүтээгдэхүүний шилдэг үйлдвэрлэгчээр: “Их морин бүлэг”

Шилдэг оролцоотой баг: Их-Усны 2-р баг



ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ТӨРЛӨӨР

1-Р БАЙР 3-Р БАГИЙН ТАРИАЛАНЧ М.БАТЖАРГАЛ, 2-Р БАЙР 3-Р БАГИЙН ТАРИАЛАНЧ
Ц.ИЧИНХОРЛОО, 3-Р БАЙР 3-Р БАГИЙН МАЗАР ДЭВШИЛ ХОРШОО

ХҮНС, ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ ТӨРЛӨӨР

1-Р БАЙР 1-Р БАГИЙН ИРГЭН Ч.СҮХДОЛГОР, 2-Р БАЙР 1-Р БАГИЙН ИРГЭН Д.ОДОНЧИМЭГ
3-Р БАЙР 1-Р БАГИЙН ИРГЭН Ч.ЭРДЭНЭЦЭЦЭГ



СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН ТӨРЛӨӨР
1-Р БАЙР 4-Р БАГИЙН МАЛЧИН О.НЭРГҮЙ
2-Р БАЙР 1-Р БАГИЙН ӨГӨӨЖ ЧАНДМАНЬ ХОРШОО
3-Р БАЙР 4-Р БАГИЙН МАЛЧИН Г.ГАНБААТАР





“Шилмэл
мал”
үзэсгэлэн
худалдаанд
хуц, ухна, эм
хонь төрөл
тус бүр дээр
3,3 байр
шалгаруулж,
өргөмжлөл
мөнгөн
шагналаар
шагнав.


1-7. Газар тариалан, эрчимжсэн аж ахуй, хүнсний үйлдвэрийн чиглэлээр туршлага судлах

1-7. Мазар дэвшил, Мазар баян хангай хоршооны төлөөлөл Төв аймгийн Баянцогт суманд чацаргана, Баянгол суманд ногоо даршлах чиглэлээр, Бат-Өлзий суманд Ургийн сүлжээ хоршоо, Дархан уул аймагт Хаяа баянговь хоршоо хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр Өгөөж чандмань хоршоо Булган аймгийн Сэлэнгэ сумын Сэлэнгэ үүлдрийн үхрийн аж ахуйтай танилцаж, бухан бяруу худалдан авч үүлдрээ сайжруулж тус тус туршлага судаллаа.



1-8 Зорилтот жилийн хүрээнд цахим орчинд иргэдийг мэдээлэлээр хангаж ажиллах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сайн туршлага, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх

1-8 Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлж байгаа шинэлэг ажлыг бичлэг болгож, Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх жил-2023 фэйсбүүк группээр дамжуулан иргэдэд танилцуулж байна. ӨВ аймгийн Соёмбо телевиз, Малчин тв, Сумын 100 жилийн ойн баримтат кино зэргээр үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг цахим орчинд сурталчилан танилцуулан ажилласан.



1-9. МАЛЧДЫН МАЛАА СААХ ДАДАЛ ХЭВШЛИЙГ ИДЭВХЖҮҮЛЭХ, УЛАМЖЛАЛТ АРГААР СҮҮ ЦАГААН ИДЭЭ БОЛОВСРУУЛАН ЗАХ ЗЭЭЛД НИЙЛҮҮЛЖ, ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНД ОРОЛЦСОН ШИЛДЭГ БАГИЙГ ШАЛГАРУУЛАХ

1-9. Малчдыг малаа саахдаа хүнсний зориулалтын саванд саах , сүү цагаан идээгээ боловсруулж, зах зээлд ингэний хоормог, аарц, сүү, ааруул зэргийг нийлүүлж, үзэсгэлэн худалдаанд сүүн бүтээгдэхүүний төрлөөр 1 хоршоо, 2 малчны бүлэг 15 иргэн оролцсноос 2-р баг шилдэг багаар шалгарсан.



1-10. ЗАЛУУ МАЛЧДЫГ ДЭМЖИХ БОЛОН АМЬЖИРГААНЫ ТҮВШИН ДООГУУР МАЛЧИН ӨРХИЙГ МАЛЖУУЛАХ

1-10. АДЗ-ИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭГДЭЖ ДЭМЖИГДСЭН 4-Н ЗАЛУУ МАЛЧИНД НЭГ ӨРХӨД 5 САЯ ТӨГРӨГИЙН БУЮУ НИЙТ 20 САЯ ТӨГРӨГИЙН ӨРТӨГ БҮХИЙ ЭМ ЯМАА 109, ИШИГ 31, ЭМ ХОНЬ 49, ХУРГА 49 НИЙТ 238 МАЛ ХУДАЛДАН АВЧ ӨГЧ МАЛЖУУЛСАН. ЗУДЫН ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ ЭРТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУСЛАМЖИНД ХАМРАГДАХ МАЛЧИН ӨРХӨД ТАВИГДАХ ШААРДЛАГА ХАНГАСАН 2-Р БАГИЙН 2 МАЛЧИН, 3-Р БАГИЙН 5 МАЛЧИН, 4-Р БАГИЙН 2 МАЛЧИН, 5-Р БАГИЙН 1 МАЛЧИН НИЙТ 10 МАЛЧИН ӨРХӨД НҮБ-ЫНН ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГААС МАЛЫН ТЭЖЭЭЛ АВАХАД 5,060,000 ТӨГРӨГ ДАНСААР, ОХИД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БАГЦ ЦҮНХТЭЙ, “АМИН ТУН” МАЛЫН ЭРДЭС ВИТАМИНЫ НЭМЭГДЭЛ, УУТ, НЭГЖ ЗЭРГИЙГ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛСЭН. ЗАЛУУ МАЛЧДЫН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН УБ ХОТОД ТӨРИЙН ОРДОНД БОЛЖ МАНАЙ СУМААС 3 МАЛЧИН ОРОЛЦЛОО.



1-11. САВ БАГЛАА БООДЛЫН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, СУРГУУЛИЙН ҮДИЙН ЦАЙНД
ОРОН НУТАГТ ҮЙЛДВЭРЛЭСЭН ЦАГААН ИДЭЭГ НИЙЛҮҮЛЭХ

1-11. “ӨВ ҮЗЭСГЭЛЭН” ХУДАЛДААНД ОРОЛЦОГЧ, ГАЗАР ТАРИАЛАН БОЛОН
СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧ ИРГЭДЭД УУТ, САВНЫ ДЭМЖЛЭГ
ҮЗҮҮЛЖ, ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН ХООЛ, СУРГУУЛИЙН ҮДИЙН ЦАЙНД
ӨГӨӨЖ ЧАНДМАНЬ ХОРШОО БОЛОН ТЭНҮҮН ГОВЬ ТАЛ ХХК ЦАГААН ИДЭЭ
ТОГТМОЛ НИЙЛҮҮЛЖ БАЙНА.



2-1.МАЛЧДАД ҮРИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ, ӨВӨЛЖӨӨ ХАВАРЖААНЫ ХӨЛД МАЛЫН ТЭЖЭЭЛ ТАРИУЛАХ

2-1.Өвөлжөө хаваржааныхаа хөлд малын тэжээл тариалах малчин өрхөд 3Д-ын нөөц хөрөнгөөр 500кг холимог үр татан авч ирж тарааснаар 10 малчин өрх 1,5 гад тариалалт хийж 5 тн холимог тэжээлээ хураан авч өвс тэжээлийн нөөцийн тодорхой хувийг бүрдүүлээд байна.



2-2. ЭРЧИМЖСЭН БОЛОН ТУСЛАХ АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ХӨНГӨЛТТЭЙ ЗЭЭЛЭЭР ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, СУРГАЛТАНД ХАМРУУЛАХ

2-2. АНУ-ын олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй Хөгжлийн шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй BEST хөтөлбөрийн төслийн зөвлөх, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 23 иргэнд “Бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах ил тод байдлыг нэмэгдүүлэх” сэдэвт сургалтыг зохион байгуулж, бизнес төсөл хэрхэн бичих талаарх гарын авлага тараан өгч, төсөл хөтөлбөрт хамрагдах боломжийн талаар мэдээлэл өгсөн. Фермерийн аж ахуйн чиглэлээр Өгөөж чандмань хоршоонд ХХСангаас хөнгөлттэй зээл олгосон.



2-3. БОГ МАЛЫН ХЭЭЛТҮҮЛЭГЧИД ҮЗЛЭГ АНГИЛАЛТ ХИЙХ, АНГИ ЧАНАРЫГ ТОГТООХ, ЯЛГАН ТЭМДЭГЛЭЖ, ЭЭМЭГЖҮҮЛЭН МАЛЫН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНД ОРУУЛАХ

2-3. Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн /Livestock.mofa.gov.mn/ программд семманталь үүлдрийн хагас эрчимжсэн 72 үхэр 1000 богыг шивж оруулаад байна. Бог малын хээлтүүлэгч малд үзлэг ангилалт хийх, хээлтүүлэгчийг ээмэгжүүлэн малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулах ажлыг зохион байгуулан 250 гаруй хээлтүүлэгчийг ангилалд оруулан малын нэгдсэн бүртгэлийн программд оруулаад байна.




2-4. Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх чиглэлээр тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийг хөнгөлттэй зээлээр дэмжиж, малчдад үйлчилгээг хүргэх

2-4. Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх чиглэлээр зөөврийн сууц, бог, бод малын зөөврын хашаа, ааруулын тавиур, аарцны шахуурга, усны ёмкос, чиргүүл, усны онгоц зэргийг үйлдвэрлэгч “Хаяа баянговь” хоршоо нь 12 ажилтантайтай, хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлттэй зээлэнд хамрагдаж, Малчдын хөдөлмөрийг хөнгөвчилсөн тоног төхөөрөмж үйлдвэрлэхээс гадна термо блок, эко хашаа зэргийг үйлдвэрлэж үзэсгэлэн худалдаанд оролцсон. Хувийн орон сууц барих иргэд дулаалга, өнгөлөгөө, даац 3-ыг нэг дор шийдвэрлэсэн теплоблокийг үйлдвэрлэж эхлээд байна. Энэ оны 11 сарын байдлаар 32ш зөөврийн сууц, бог бод малын хашаа 8ш, зөөврийн чиргүүл, ёмкос 2ш үйлдвэрлэж хүргэлтээр хүргэж өгч байна.







3. Газар тариалангийн салбарын зорилтын хүрээнд:

3-1. Хүнсний ногооны зоорь барих, сэргээн засварлах, ашиглалтыг сайжруулах

3-1. Өмнөх онд Зах зээл ба бэлчээрийн удирдлагын төслөөс 70%-ийг, орон нутгийн хөгжлийн сангаас 30%-ийн хөрөнгө оруулалтай 50 тонны зоорь барьж ашиглалтанд оруулсан. Хоршоог хөгжүүлэх сангаас 1 хоршоо зоорь засварлах, хүлэмж барих зориулалтаар хөнгөлөлттэй зээлэнд хамрагдаж 10 тн-ы зоорины засвар болох блок шинэчлэх, дээвэр хуулах, шороо зайлуулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Мөн Хаяа баян говь хоршоо 40 тн багтаамжтай төмс, хүнсний ногооны төрөлжсөн зоорийг шинээр барьсан.

3-2. Тариаланчдад техник тоног төхөөрөмж, гар багажны дэмжлэг үзүүлэх, хөнгөлттэй зээл, төсөл хөтөлбөрт хамруулах

3-2. Хоршоог хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлээр 1 аж ахуйн нэгж, нэг тариаланч хувийн хөрөнгөөр мотоблок, сийрүүлэгч, хүнсний ногооны үрлэгч 3 ширхэгийг худалдан авсан. Швед улсын Интеракт азт олон улсын байгууллагын санхүүжилтээр Өрхийн тариалан бизнес хөгжил ТББ-ын хэрэгжүүлж буй “ХАА эрхлэгчдийн даван туулах чадварыг сайжруулах” төсөл нь 2023-2026 онд хэрэгжинэ. Төслийн багийхан ирж малчид, тариаланчидад төслөө танилцуулан шалгуур үзүүлэлт болон судалгаа бөглүүлэн 20 тариаланч, 10 малчин сонгон авч төсөлд хамрагдсан иргэдэд эхний сургалт болон дадлага ажлуудыг сургагч багш нар хийж, төслийн зохицуулагчаар А.Донидыг сонгон цаашид мазар багт ойн зурвас байгуулах, төсөлд хамрагдсан иргэдэд ногооны үр болон гар багажаар хангах, төслийн үр дүнгийн талаар танилцууллаа.



3-3. Хүлэмжийн цогцолбор аж ахуйтай болох

3-3. 2022 онд Засаг даргын Тамгын газрын нэр дээр 20 га атаршсан газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулахаар батлуулан, 2 гүн өрмийн худаг гаргах, хашаажуулах ажлыг Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөлтэй хамтран хийж, энэ жил шинээр 990 ширхэг улиас, 310 ширхэг бургас тариалж хүлэмжний цогцолбор аж ахуй байгуулах ойн зурвасаа байгуулж, хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах газрыг хагалж хөрсийн бэлтгэсэн аймгаас 2 хүлэмж оройтож ирсэн тул тариалалт хийж амжаагүй.

3-4. Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг эрхлэх иргэн, аж ахуй нэгжийг хөнгөлттэй зээлэнд хамруулах

3-4. Хоршоог хөгжүүлэх сангийн дэмжлэгээр 1 иргэн, 1 хоршоо ХЭДСангаас 3 тариаланч хамгаалагдсан хөрсний тариалалт хийх зориулалтаар 15 сая төгрөгний зээлэнд хамрагдаж 180 м² хүлэмж худалдан авч өмнөх оноос хамгаалагдсан хөрсний тариалалт 296 м²-аар, ургацын хэмжээ 3,8 тн-оор нэмэгдлээ.



3-5. УСЛАЛТЫН СИСТЕМ, УСАЛГААНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, УСАЛГААТАЙ ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

3-5. Хөдөө аж ахуйг дэмжих сангаас 1 га болон 3 га-ын услалтын систем, 1 аж ахуйн нэгж Хоршоог хөгжүүлэх сангийн дэмжлэгээр 5 тн-ын усан сан, худгийн насос зэргийг худалдан авч, техник тоног төхөөрөмжөө нэмэгдүүлээд байна. Мазар багийн тариалангийн талбайд 50га-ийн услалтын системийг зээлээр авсанаар усалгаатай тариалангийн талбай 5 га-аар нэмэгдсэн.



3-6. ЖИМС, ЖИМСГЭНЭ ТАРИАЛАХ ИРГЭДЭД 300-ААС ДООШГҮЙ СУУЛГАЦЫН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

3-6. Хоршоог хөгжүүлэх сангийн дэмжлэгээр 1 аж ахуйн нэгж, хувийн хөрөнгөөр 2 тариаланч нийт 230 ширхэг чацарганы мод суулгаж энэ жил 0,5тн жимс хураан авсан.

3-10. Үүлэнд зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах

3-10. Малын тоо, толгойн албан татвараас хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэхэд 3 сая төгрөгийн төсөв батлуулан аймгийн цагуурын газарт шилжүүлсэн.



3-7. Сонгино, саримс, хүлэмжний нарийн ногооны тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор үрийн дэмжлэг үзүүлэх

3-8. Хүнс, Хөдөө ах ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас газраас тариалан эрхлэгчдэд 80%-ийн хөнгөлөлттэй үр олгосноос манай суманд төмс- 500 кг, сонгино-700кг, сармис-20кг, байцаа-2000 ширхэг, шар лууван-5 кг, шар манжин-500 гр, хүрэн манжин- 500 гр, бууцай-500 гр, өргөст хэмх-1300 ширхэг, лооль-10 гр, урт сонгино-500 гр, чинжүү-500 гр тус тус хувиарласаныг 55 тариаланч, 3 албан байгууллага, 2 хоршоонд хувиарлан өгч тариалалт хийснээр өмнөх оноос хүнсний ногооны ургацын хэмжээ 35,3 хувиар өссөн.



3-8. МАЗАРЫН ДАЛАНГИЙН ЛАГ ШАВРЫГ ЗАЙЛУУЛЖ, ХАЯХЫН ХААЛТЫГ СОЛИХ

Мазарын далангийн лаг шаврыг зайлуулах тендерийг 3 сараас эхэлж 3 удаа зарласан боловч төсөв хангалтгүй гэдэг шалтгаанаар нь аж ахуйн нэгжүүд орж ирээгүй тул орон нутгийн “Сүүн төгрөг ХХК” компанид санал тавьж, аймгийн ОНХСангийн 100 сая төгрөг, сумын ОНХСангийн 20 сая төгрөгийн санхүүжилтээр 40800 м³ лаг шаврыг ухаж цэвэрлэн, 14 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.



4. ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

4-1. Хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлттэй зээлийн бодлогоор дэмжих, Хүнсний бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тэнцэл тооцож ажилласан эсэх

4-1. Хоршоог хөгжүүлэх санд төсөл хүлээн авах зарыг цахим орчинд зарлан төслүүдийг хүлээн авч хэлэлцэн 10 сард 2 хоршоо, 2 иргэнд 119 сая төгрөгийн хөнгөлттэй зээл олгосон үүний 26 сая төгрөг нь сүү,сүүн бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлийн чиглэлд олгосон. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг нэгж бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох коэффициент батлах тухай а/162 дугаар тушаал, Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, амин дэм эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах тухай эрүүл мэндийн сайдын А/74 тушаалыг үндэслэн хүнсний тэнцлийг улирал болон хагас, бүтэн жилээр тооцон холбогдох байгууллагад хүргүүлээд байна. Дотоодын үйлдвэрлэлээр мах болон сүүг 100 хувь, гурилан бүтээгдэхүүн 1,1 хувь, төмс 100 хувь, хүнсний ногоо 61,8 хувийг хангаад байна.



4-2. СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН ХООЛ ҮЙЛДВЭРИЙН ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР АРГА ХЭМЖЭЭ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

4-2. Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хүрээнд нийтийн хоол, худалдаа үйлчилгээний стандартыг сурталчлах, хэрэгжилтийг хангуулах талаар хүнсний худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 7 дэлгүүр, төсөвт байгууллагын нийтийн хоолны газруудад улсын байцаагч нарын хамт эрүүл ахуй, бүтээгдэхүүний хадгалалт, хугацаа зэрэгт хяналт тавьж, мэргэжил арга зүйн заавар зөвлөгөөгөөр хангаж ажиллалаа. Мөн Ахлах, дунд ангийн 120 гаран сурагчдын дунд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Зорилтот жилийн хүрээнд хүнсний худалдаа үйлдвэрлэл эрхлэгчид болон нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэд болон төсөвт байгууллагын тогооч нар үзэсгэлэн худалдаа болон нээлтийн арга хэмжээний үеэр хоолны үзэсгэлэн гаргаж амталгаа хийлгүүлж иргэдэд үйлчилсэн.



4-3. ХҮНС ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХДИЙН ХООЛНЫ ДЭЭЖИЙГ МХГ-ЫН ЛАБОРАТОРТ ШИНЖИЛГЭЭНД ХАМРУУЛАХ

4-3. ЕБСургууль, Цэцэрлэгийн хүүхдийн хоолны үзэсгэлэн гаргаж, амталгаа хийлгэн ХХААГ-ын Хяналтын албаны дарга болон байцаагч нар хоолны илчлэг, аюулгүй байдал дээр заавар зөвлөгөө өгч ажиллаа. Мөн хоолны дээжийг улирал ЕБСургууль, Цэцэрлэгийн хүүхдийн хоолны дээжийг улирал бүр шинжилгээнд хамруулж хэвшээд байна. Мөн үйлдвэрлэл эрхлэгч Ч.Сүхдолгорын Гоёоны дарсыг лабораторийн шинжилгээнд хамруулаад байна. Ундны усыг шинжилгээнд хамруулсан.



4-4. МАЛЧДАД МАЛЫН ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТ, УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ТӨРӨЛ БҮРИЙН НӨЛӨӨЛЛИЙН АРГА ХЭМЖЭЭГ ШАТ ДАРААТАЙГААР ЗОХИОН БАЙГУУЛАХ

4-4. “Малчдын бүсийн зөвлөгөөн”-ийг Баянгол суманд зохион байгуулж, Арвайхээр, Сант, Төгрөг, Баянгол сумын 370 гаруй малчид оролцсон зөвлөгөөнөөр малын эмчийн үүргийг түр хариуцаж байгаа аймгийн мал эмнэлэгийн мэргэжилтэн малын эмийн зохистой хэрэглээний талаар сургалт мөн суманд баг бүрээс 20 малчинд сургалт зохион байгуулж АХА тэмцээн явуулж гарын авлага тараан өгсөн. 2023 оны 06 дугаар сарын 13-нд Төгрөг суманд Мал эмнэлгийн газрын ажлын хэсэг ажилласан. Шүлхий өвчний дархлаажуулалтын хяналт хийж ТМЗА мал эмнэлгийн эзэн малын их эмч Г.Бүүвэйбаатарт Мал эмнэлгийн улсын байцаагч Б.Ариунцэцэг зөрчил арилгуулах талаар хугацаатай зөвлөмж хүргүүлж зөрчлийг арилгуулсан.

4-5. “ХҮНСНИЙ ЗОРИУЛАЛТЫН БУС САВЫГ ХҮНСЭНД ХЭРГЛЭХЭЭС ТАТГАЛЗСАН СУМ” БОЛОХ, МАЛЧИД СҮҮ, ЦАГААН ИДЭЭГЭЭ ХҮНСНИЙ ЗОРИУЛАЛТЫН САВАНД БОЛОВСРУУЛАХ, ХАДГАЛАХ ЧИГЛЭЛЭЭР ТӨРӨЛ БҮРИЙН СУРГАЛТ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ

4-5. Хүнсний зориулалтын бус хуванцар савыг хэрэглээнээс халсан сум болох аяны хүрээнд ЕБС, хүүхдийн цэцэрлэг, багуудаар зорилтот жилийн хавтасыг аялуулж албан байгууллагууд төлөвлөгөө гарган сургалт зохион байгуулж, 165 иргэдийг хамруулсан.. Мөн нээлтийн арга хэмжээний үеэр Чиглэл ХХК-ыг хүнсний зориулалтын зэвэрдэггүй ган савнуудыг иргэдэд танилцуулж худалдан авалт хийгдлээ. Эцэг эхчүүдээс Цэцэрлэгт 110 болон 60 литрийн савнуудыг хандивласан. Мөн ЕБС-ийн ахлах ангийн 123 сурагчдад Хүнсний аюулгүй байдал, хүнсний зориулалтын бус хуванцар савны хор уршгийн талаарх сургалтыг зохион байгуулсан. ЕБСургууль төлөвлөгөө гарган хими биологийн багш нараар удирдуулан бага, дунд болон ахлах ангийн сурагчдын дунд сургалт, АХА тэмцээн, 220 ш гарын авлага тараан өгсөн. Хүүхдийн цэцэрлэг аяны хүрээнд төлөвлөгөө гарган бага бүлгийхэнд хүнсний зориулалтын савыг ялгаж таних, эцэг, эхчүүдэд нь сургалт хийх, дунд, ахлах бүлгийхэнд төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулж 144 хүүхэд, 82 эцэг эх хамрагдаж, хуванцар савны хор уршгийн талаар хүүхдүүдээр дамжуулан эцэг, эхчүүдэд нь нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулсан нь үр дүнтэй болж, өмнөх оноос хүнсний зориулалтын кодтой сав, ган нержен сав, модон сав хэрэглэсэн өрхийн тоо 20 хувиар өссөн байна.



ИХ-УСНЫ 2-Р БАГИЙН “ИХ МОРИН” АРАВТЫН БҮЛГИЙХЭН



**Анхаарал хандуулсанд
баярлалаа**



**3-5. Ургамал
хамгаалал,
эрдэм
шинжилгээний
хүрээлэнгийн 5
эрдэмтэнээс
бүрдсэн баг ирж
Мазарын
тариалангийн
талбайн өвчин
хортон, хог
ургамал, мэрэгч
амьтдыг
тододгох
судалгаа хийж
тариаланчдад
заавар, зөвөлгөө
өгч ажиллаа**





4-6. ХЭРЭГЛЭГЧДЭД ХООЛ, ХҮНСНИЙ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААР СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

ЭМТөвтэй хамтран албан байгууллагууд, иргэдийн дунд хүнсний зохистой хэрэглээний талаарх сургалтыг зохион байгуулж, 115 иргэн хамрагдсан. ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад хоол хүнсний зохистой хэрэглээ, хүнсний аюулгүй байдлаар сургалт хийж гарын авлага тараасан.